



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТНОРОВ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 09 сарын 18 өдөр

Дугаар А/120

Батноров сум

Бог малын мялзан өвчнөөс урьдчилан
сэргийлэх дархлаажуулалтын ажлыг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, 9.9 дэх заалт, Хэнтий аймгийн Мал эмнэлгийн газрын даргын 2024 оны 09 сарын 17-ны А/50 тоот тушаал, Аймгийн засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 17 ны А/471 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2024 онд шинээр гарсан сумын хэмжээний мэдрэмтгий төл мал хурга, ишгийг уг өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулах ажлыг шуурхай зохион байгуулж технологит хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэхийг Дэлгэрэхсүрэг ХХК-ий захирал А.Мөнхбаяр, "Бөмбөг шарга" ХХК-ий захирал (Б.Баясгалан), "Мааньт хөхий" ХХК-ий захирал (Ш.Эрдэнэчимэг), "Энхсүрэг" ХХК-ний захирал (Г.Өсөхбаяр), "Ажнай вит" ХХК-ний (С.Болдбаатар), Малын их эмч (Н.Мөнхтуяа), Хувирахуй ХХК-ний захирал М.Алтанчимэг нарт тус тус үүрэг болгосугай.
2. Малчдад урьдчилан мэдэгдэж тарилгын хашаа, хоолойг бэлтгүүлэн, мал сүргээ бэлэн байлгах ажлыг урьдчилан мэдэгдэж, хяналт тавьж ажиллахыг багийн Засаг дарга нарт даалгасугай.
3. Урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад мал сүргээ бүрэн хамруулаагүй, хамруулахаас зайлсхийсэн малчид мал бүхий иргэд заавар журмыг баримтлаагүйн улмаас малын өвчин гарах нөхцөлийг бүрдүүлсэн албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн Улсын байцаагч (Т.Жаргалцэцэг) үүрэг болгосугай.
4. Дархлаажуулалтад шаардлагатай вакцин, мэргэжил арга зүйн заавар, зөвлөмжөөр хангах, гүйцэтгэлийг хянаж шалгах, холбогдох газарт цаг хугацаанд нь мэдээ, мэдээллийг хүргэж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн Улсын байцаагч (Т.Жаргалцэцэг)-д, даалгасугай.
5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч дарга (Б.Ган-Эрдэнэ)-д тус тус даалгасугай.



Б.ЖАВХЛАНБАЯР

230423258